

БУЛГИЙН ЭХИЙГ ХАШИЖ ХАМГААЛАХ, ТОХИЖУУЛАХ  
АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2019.12.26

Хэрлэн сум

**1.Байршил:**

- 1.Баяндун сум Баруун наймганы булаг /сумын төвөөс урагш 30 км/
- 2.Баяндун сум Түргэн цагаан нуурын тэжээгдлийн булаг /сумын төвөөс 40 км/
- 3.Баян-Уул сум Хурандаа булаг /сумын төвөөс хойш 25 км/
- 4.Баян-Уул сум Хустын булаг /сумын төвөөс зүүн урагш 25 км /
- 5.Баянтүмэн сум Сүүл нуурын булаг /сумаас зүүн тийш 50 км /
- 6.Дашбалбар сум Шандын булаг /сумын төвөөс 50 км/

**2.Булгийн эхийг хашиж хамгаалах ажил хийх арга технологи, техникийн шаардлага**

**2.1.Техникийн шийдэл**

Булгийн эхийг хашиж хамгаалахад дараах үндсэн шаардлагуудыг удирдлага болгохыг зөвлөж байна.

Үүнд:

1. Булгийн эх нь малын хөлөөс бүрэн хамгаалагдсан байх
2. Булгийн ундарга, эхийг хөндөж муутгахгүй байх
3. Булгийн ундаргад тулалт үүсгэхгүй байх
4. Төмөр хийц, материал сонгож бат бөх хийх
5. Хүйтний улиралд булгийг ашиглах боломжтой байх
6. Булгийн эхийг хамгаалахдаа нэг хийц загварыг сонгох

**2.2.Хамгаалах арга**

Булгийн эхийг хамгаалах хашааг 24 х 26м<sup>2</sup> хэмжээтэй төмөр хийц материалаар нийт 100 метр урттай хийнэ. Булгийн ус цуглуулах талбайн хэмжээнээс хамааран хашааны хэлбэр 4 тал буюу тойрог байж болно. Хашааг 1\*2 см<sup>2</sup> өргөн, хөндлөвчийг 1\*4 см<sup>2</sup> хөндий төмрөөр гагнаж хийнэ.

Хашааны өндөр 120 см,

Шонгийн нийт урт 180 см

Шон хоорондын зай 200 см,

Хашааны сараалж хооронд 15 см,

Хашааны төмөр шонгийн диаметр 8-10 см-ийн голчтой төмөр трубагаар хийж, дээд талыг битүүлж, зэврэлтээс хамгаалж төмрийн будгаар будна. Шонг 50 см гүнд суулгаж, зэвэнд идэгдэж урвалд орохоос хамгаалан байгалийн чулуугаар чигжиж цементэлнэ.

Булгийн урсацын доод талд буюу булгийн хөлд 80 см өргөнтэй гадагш онгойдог,

явган хаалга хийж хогийн сав байрлуулна.

Булгийн эхийг хамгаалсан хашаан дотор 10-аас доошгүй мод тарьсан байна.

Усны нөөцийг бохирдлоос хамгаалах талаарх сурталчилгааны самбарыг 80x60 хэмжээтэй 2 мм зузаан гөлмөн төмрөөр хийж, хашаанд гагнаж бэхлэнэ.

Самбарт тавигдах мэдээллийг сайн чанарын гадна зориулалтын хэвлэл эсвэл гэрэл ойлгогчтой будаг ашиглаж хийнэ. Самбарын 2 талд мэдээллийг байрлуулна. Самбарт байрлуулах мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын газраас авна.

